



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/078/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэбулган хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2026.02.25 № 130  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ТАРИАТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН Г  
ТӨВИЙН ДАРГА Л.УНДАРМАА  
ТАНАА

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Тариат сумын Эрүүл мэндийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,
- Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээнд заасан эм эмнэлгийн хэрэгслийг худалдан аваагүй 3,766.8 мянган төгрөг,
- Эм боох бараа материалын үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ авч ажиллаагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй 55,530.8 мянган төгрөг,
- Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан 1,437.5 мянган төгрөг,
- Эрүүл мэндийн салбарын ажилчдын шөнийн цагаар ажилласны нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоосон тарифаас өндөр дүнгээр олгосон 149,822.3 мянган төгрөг,
- Тайлант оны санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэл, ХАОАТ-ын өр төлбөр үүсгэсэн 58,500.0 мянган төгрөгийн зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 18.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.2, 16.5.3, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72

дугаар зүйлийн 72.4 дахь заалтуудыг зөрчсөн иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 17355 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,752,751.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 414,916.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 26,850.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Япон улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар 799,926.0 мянган төгрөгийн өргөтгөлийн барилга, Эрүүл мэндийн газраас 5,090.0 мянган төгрөг, хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлснээр 28,139.7 мянган төгрөгийн, хандив тусламжаар 27,640.0 мянган төгрөгийн нийт 1,195,583.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 33,386.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 78.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>439,952,834.49</b>	<b>75,996,744.79</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	20,103,481.94	0.83
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	20,103,481.94	0.83
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	20,103,481.94	0.83
31211	Төрийн сангийн харилцах	20,103,481.94	0.83
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	299,422,555.39	5,424,786.80
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	299,422,555.39	3,566,323.70
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	1,858,463.10
3351	Байгууллагаас авах авлага		1,858,463.10
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	120,426,797.16	70,571,957.16
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	93,067,265.94	49,628,465.04
35110	Тусгай зориулалттай материал	6,576,500.00	13,701,500.00
35130	Эм боох материал	86,490,765.94	35,926,965.04
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	27,359,531.22	20,943,492.12
35410	Бичиг хэргийн материал	537,196.00	550,175.00
35420	Аж ахуйн материал	21,766,647.12	19,090,113.12
35450	Барилгын засварын материал	-	610,000.00
35460	Хүнсний материал	2,909,402.00	693,204.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,211,293,053.44</b>	<b>3,202,691,372.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,211,293,053.44	3,202,691,372.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,173,827,803.31	3,165,371,122.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,564,363,583.00	3,672,196,382.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(908,132,495.61)	(947,221,258.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	233,000,000.00	233,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(68,598,312.37)	(102,709,062.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	677,759,664.87	632,148,390.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(360,197,207.88)	(346,389,319.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,763,751.67	74,794,262.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,770,222.13)	(51,437,593.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,007,589.00	7,219,039.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,368,547.24)	(6,229,716.72)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	37,465,250.13	37,320,250.17
39301	Програм хангамж	1,450,000.00	1,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(538,749.87)	(683,749.83)
39303	Бусад биет бус хөрөнгө	36,554,000.00	36,554,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,651,245,887.93</b>	<b>3,278,688,117.38</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,200,000.00</b>	<b>63,427,921.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,200,000.00	63,427,921.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,200,000.00	63,427,921.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	60,983,771.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,444,150.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,650,045,887.93</b>	<b>3,215,260,196.38</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,650,045,887.93	3,215,260,196.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	268,895,547.95	268,895,547.95
51101	Өмч: - төрийн	268,895,547.95	268,895,547.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	998,956,237.37	1,564,570,573.05
51210	Өмнөх үеийн үр дүн	998,956,237.37	999,356,264.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	565,214,308.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,382,194,102.61	1,381,794,075.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,651,245,887.93</b>	<b>3,278,688,117.38</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,927,149,267.46</b>	<b>2,859,806,215.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>312,024,342.82</b>	<b>987,995,195.10</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	312,024,342.82	987,995,195.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	312,024,342.82	987,995,195.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,528,000.00	93,782,513.00
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ	257,297,919.00	860,826,582.44
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - БМ	51,198,423.82	33,386,099.66
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,615,124,924.64</b>	<b>1,871,811,020.20</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	101,630,000.00	414,916,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	101,630,000.00	414,916,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,513,494,924.64	1,456,895,020.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,513,494,924.64	1,456,895,020.20
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,664,747,443.72</b>	<b>2,294,567,326.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,664,747,443.72</b>	<b>2,294,567,326.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,615,502,474.79	2,125,203,215.66
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,000,352,404.00	1,393,321,428.00
210101	Үндсэн цалин	437,843,174.00	543,875,126.00
210102	Нэмэгдэл	471,215,792.00	720,680,094.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,993,000.00	35,095,023.00
210104	Урамшуулал	84,300,438.00	93,671,185.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	127,543,619.00	178,127,322.00
210201	Тэтгэврийн даатгал	85,487,661.00	120,937,731.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,626,639.00	14,297,497.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,730,320.00	7,146,049.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,939,920.00	7,146,049.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,759,079.00	28,599,996.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,627,031.07	53,226,465.00
210301	Гэрэл, цахилгаан	8,759,631.07	11,011,629.00
210302	Түлш, халаалт	37,705,800.00	41,464,836.00
210303	Цэвэр, бохир ус	1,161,600.00	750,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,505,798.99	50,292,077.00
210401	Бичиг хэрэг	5,058,040.00	4,213,221.00
210402	Тээвэр, шатахуун	33,932,859.99	30,421,722.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,952,000.00	5,951,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,152,000.00	1,971,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,410,899.00	7,734,034.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	160,239,190.35	194,120,248.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	134,682,890.35	171,930,650.56
210502	Хоол, хүнс	22,582,000.00	17,006,598.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,974,300.00	5,183,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,297,000.00	16,236,968.00
210604	Урсгал засвар	7,297,000.00	16,236,968.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,599,900.00	8,970,750.00
210701	Гадаад албан томилолт	2,500,000.00	1,615,950.00
210702	Дотоод албан томилолт	8,099,900.00	7,354,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,486,000.00	18,041,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	16,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,700,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	91,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	32,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	288,000.00	318,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	198,851,531.38	212,866,457.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,629,042.00	8,705,981.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,222,489.38	204,160,476.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	49,244,968.93	201,838,047.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	127,157,337.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	63,835,337.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	26,322,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	37,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	49,244,968.93	74,680,710.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,244,968.93	74,680,710.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>262,401,823.74</b>	<b>565,238,888.64</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	6,930,000.00	24,580.19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,930,000.00	24,580.19
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(6,930,000.00)	(24,580.19)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>255,471,823.74</b>	<b>565,214,308.45</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,350,042,547.25</b>	<b>2,261,449,764.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,528,000.00</b>	<b>93,782,513.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,528,000.00	93,782,513.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,528,000.00	93,782,513.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,528,000.00	93,782,513.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,346,514,547.25</b>	<b>2,167,667,251.89</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	101,630,000.00	414,916,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	101,630,000.00	414,916,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,244,884,547.25	1,752,751,251.89
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,244,884,547.25	1,752,751,251.89
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,435,473,611.00</b>	<b>2,254,703,246.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,435,473,611.00</b>	<b>2,254,703,246.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,386,228,642.07</b>	<b>2,052,865,199.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,000,352,404.00	1,355,893,188.00
210101	Үндсэн цалин	437,843,174.00	506,446,886.00
210102	Нэмэгдэл	471,215,792.00	720,680,094.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,993,000.00	35,095,023.00
210104	Урамшуулал	84,300,438.00	93,671,185.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	127,543,619.00	154,571,791.00
210201	Тэтгэврийн даатгал	85,487,661.00	104,919,971.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,626,639.00	12,413,055.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,730,320.00	6,203,827.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,939,920.00	6,203,827.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,759,079.00	24,831,111.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,462,031.07	53,226,465.00
210301	Гэрэл, цахилгаан	8,759,631.07	11,011,629.00
210302	Түлш, халаалт	37,540,800.00	41,464,836.00
210303	Цэвэр, бохир ус	1,161,600.00	750,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	54,827,370.00	47,745,699.00
210401	Бичиг хэрэг	5,305,000.00	4,226,200.00
210402	Тээвэр, шатахуун	34,000,000.00	29,445,899.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,952,000.00	5,951,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,872,500.00	1,808,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,697,870.00	6,314,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	127,093,776.00	104,945,000.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,062,676.00	89,224,800.00
210502	Хоол, хүнс	22,281,100.00	13,870,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,750,000.00	1,850,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,164,500.00</b>	<b>299,404,825.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,485,000.00	7,125,000.00
210604	Урсгал засвар	7,679,500.00	292,279,825.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,599,900.00</b>	<b>8,970,750.00</b>
210701	Гадаад албан томилолт	2,500,000.00	1,615,950.00
210702	Дотоод албан томилолт	8,099,900.00	7,354,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,286,000.00</b>	<b>18,191,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	16,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	91,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	32,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	288,000.00	318,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,899,042.00</b>	<b>9,915,981.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,899,042.00	9,915,981.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,244,968.93</b>	<b>201,838,047.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>127,157,337.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	63,835,337.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	26,322,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	37,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>49,244,968.93</b>	<b>74,680,710.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,244,968.93	74,680,710.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(85,431,063.75)</b>	<b>6,746,518.89</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>16,219,690.00</b>	<b>26,850,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,219,690.00</b>	<b>26,850,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>16,219,690.00</b>	<b>26,850,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,219,690.00	26,850,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(16,219,690.00)</b>	<b>(26,850,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(101,650,753.75)</b>	<b>(20,103,481.11)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>20,103,481.94</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,103,481.94</b>	<b>0.83</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,895,547.95	1,382,194,102.61	743,484,413.63	2,394,574,064.19
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	268,895,547.95	1,382,194,102.61	743,484,413.63	2,394,574,064.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	400,027.23	400,027.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,895,547.95	1,382,194,102.61	743,884,440.86	2,394,974,091.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(400,027.23)	-	(400,027.23)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	565,214,308.45	565,214,308.45
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,895,547.95	1,381,794,075.38	1,309,098,749.31	2,959,788,372.64

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2.00	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,513,415,200.00	2,206,872,536.00	306,542,664.00	0.88
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	2,513,415,200.00	2,206,872,536.00	306,542,664.00	0.88
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,385,959,800.00	2,079,715,199.00	306,244,601.00	0.87
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,484,799,400.00	1,355,893,188.00	128,906,212.00	0.91
210,101.00	Үндсэн цалин	725,466,300.00	506,446,886.00	219,019,414.00	0.70
210,102.00	Нэмэгдэл	569,015,800.00	720,680,094.00	(151,664,294.00)	1.27
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	33,536,700.00	35,095,023.00	(1,558,323.00)	1.05
210,104.00	Урамшуулал	156,780,600.00	93,671,185.00	63,109,415.00	0.60
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,111,400.00	154,571,791.00	30,539,609.00	0.84
210,201.00	Тэтгэврийн даатгал	124,625,000.00	104,919,971.00	19,705,029.00	0.84
210,202.00	Тэтгэмжийн даатгал	15,121,600.00	12,413,055.00	2,708,545.00	0.82
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	7,560,800.00	6,203,827.00	1,356,973.00	0.82
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	7,560,800.00	6,203,827.00	1,356,973.00	0.82
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	30,243,200.00	24,831,111.00	5,412,089.00	0.82

<b>2,103.00</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	81,896,000.00	53,226,465.00	28,669,535.00	0.65
210,301.00	Гэрэл, цахилгаан	20,100,000.00	11,011,629.00	9,088,371.00	0.55
210,302.00	Түлш, халаалт	59,996,000.00	41,464,836.00	18,531,164.00	0.69
210,303.00	Цэвэр, бохир ус	1,800,000.00	750,000.00	1,050,000.00	0.42
<b>2,104.00</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	69,699,800.00	47,745,699.00	21,954,101.00	0.69
210,401.00	Бичиг хэрэг	5,489,900.00	4,226,200.00	1,263,700.00	0.77
210,402.00	Тээвэр, шатахуун	42,629,000.00	29,445,899.00	13,183,101.00	0.69
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,182,900.00	5,951,600.00	3,231,300.00	0.65
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,998,000.00	1,808,000.00	1,190,000.00	0.60
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,400,000.00	6,314,000.00	3,086,000.00	0.67
<b>2,105.00</b>	<b>Нормативт зардал</b>	128,238,800.00	104,945,000.00	23,293,800.00	0.82
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	97,845,900.00	89,224,800.00	8,621,100.00	0.91
210,502.00	Хоол, хүнс	24,642,600.00	13,870,200.00	10,772,400.00	0.56
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,750,300.00	1,850,000.00	3,900,300.00	0.32
<b>2,106.00</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	395,314,400.00	326,254,825.00	69,059,575.00	0.83
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	50,993,700.00	33,975,000.00	17,018,700.00	0.67
210,604.00	Урсгал засвар	343,411,000.00	292,279,825.00	51,131,175.00	0.85
<b>2,107.00</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,800,000.00	8,970,750.00	2,829,250.00	0.76
210,701.00	Гадаад албан томилолт	1,616,000.00	1,615,950.00	50.00	1.00
210,702.00	Дотоод албан томилолт	10,184,000.00	7,354,800.00	2,829,200.00	0.72
<b>2,108.00</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,950,000.00	18,191,500.00	758,500.00	0.96
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,100,000.00	16,100,000.00	-	1.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,050,000.00	1,650,000.00	400,000.00	0.80
210,803.00	Даатгалын үйлчилгээ	200,000.00	91,000.00	109,000.00	0.46
210,804.00	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	32,000.00	68,000.00	0.32
210,808.00	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	318,500.00	181,500.00	0.64
<b>2,109.00</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,150,000.00	9,915,981.00	234,019.00	0.98
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	10,150,000.00	9,915,981.00	234,019.00	0.98
<b>213.00</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	127,455,400.00	127,157,337.00	298,063.00	1.00
<b>2,132.00</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	127,455,400.00	127,157,337.00	298,063.00	1.00
213,207.00	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,133,400.00	63,835,337.00	298,063.00	1.00
213,208.00	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,322,000.00	26,322,000.00	-	1.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,000,000.00	37,000,000.00	-	1.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,513,415,281.94	2,186,769,054.89	326,646,227.05	0.87
<b>1,320.00</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	414,916,000.00	340,235,290.00	74,680,710.00	0.82
132,001.00	Орон нутгийн төсвөөс	414,916,000.00	340,235,290.00	74,680,710.00	0.82
<b>1,340.00</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,984,648,300.00	1,752,751,251.89	231,897,048.11	0.88
134,002.00	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,984,648,300.00	1,752,751,251.89	231,897,048.11	0.88

120,004.00	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	113,850,981.94	93,782,513.00	20,068,468.94	0.82
1,200,042.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93,747,500.00	93,782,513.00	(35,013.00)	1.00
4.00	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	20,103,481.94	<b>20,103,481.94</b>	-	1.00
5.00	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>0.83</b>	(0.83)	
61.00	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	1.00
610,001.00	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	1.00
62.00	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	33.00	33.00	-	1.00
620,001.00	Удирдах ажилтан	1.00	1.00	-	1.00
620,002.00	Гүйцэтгэх ажилтан	28.00	23.00	5.00	0.82
620,003.00	Үйлчлэх ажилтан	4.00	9.00	(5.00)	2.25
65.00	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>33.00</b>	<b>33.00</b>	-	1.00
650,008.00	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	29.00	24.00	5.00	0.83
650,009.00	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	9.00	(5.00)	2.25

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 270,915.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд 1,858.4 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

Тайлант оны түлш шатах тослох материалын үлдэгдэлд А-92 бензин 275 л, дизель түлш 318 л байгааг хянаж үзэхэд бараа материал бодитоор байхгүй, харилцагч байгууллагад илүү шилжүүлсэн 1,858.4 мянган төгрөгийн дүнгээр хий орлого бүртгэснийг аудитын явцад байгууллагаас авах авлагаар залруулан бүртгүүлэв.

Аудитаар залруулагдаагүй 269,056.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 4 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 269,056.6 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 17,149.0.4 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох авто машины сэлбэг, аж ахуйн материал худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1,437.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 211 дугаар тушаалын тавдугаар хавсралт “Урсгал зардлын ангилалын тайлбар”,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын тодорхойлолт” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 3,766.0 мянган төгрөг, тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, хуулийн 39.1-д “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид "худалдан авах гэрээ" гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна.” 39.2 -д” .Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэснээс эм боох материалын үлдэгдэл өндөр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, эм боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг хэрэглээгүй, эм боох материалын тооллого тооцоо хийж акт үйлдээгүйтэй холбоотой 55,530.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Эрүүл мэндийн салбарын ажилчдын шөнийн цаг ажилласны нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоосон тарифаас өндөр дүнгээр олгосон 149,822.3 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйл “ ээлжийн ажлын цаг “ 87.4-д “.Ажилтныг хоёр ээлжид дараалуулан ажиллуулахыг хориглоно.”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/69 дугаар тушаалын 1.4-д "Хөдөлмөрийн тухай хуулийн 72.1

дэх заалтын дагуу 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад "шөнийн цаг ажилласны нэмэгдэл"-ийг 1 цаг тутамд 1000 төгрөгөөр тооцож олгох " гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.2.4. Тайлант оны санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэл, ХАОАТ-ын 58,500.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх".16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" 16.5.3 -д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Авлага буруу тусган бүртгэсэн	1	1,858.4			1	1,858.4	1	1,858.4		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,858.4</b>			<b>1</b>	<b>1,858.4</b>	<b>1</b>	<b>1,858.4</b>		

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй		3,766.0				3,766.0
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан " Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл"нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,					1	0
Эм боох бараа материалын үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй,	1	55,530.80			1	55,530.80
Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	1,437.50	1	1,437.50		
Эрүүл мэндийн салбарын ажилчдын шөнийн цаг ажилласаны нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоосон тарифаас өндөр дүнгээр олгосон	1	149,822.30			1	149,822.30
Тайлант оны санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэл, ХАОАТ-ын өр төлбөр үүссэн,	1	58,500.00			1	58,500.00
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>269,056,6</b>	<b>1</b>	<b>1437.5</b>	<b>4</b>	<b>267,619.1</b>